

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453799, Цахим хаяг: AyushR@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/01/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

**ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

E:/sta-2023/A4-blank.docx

0200200720

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over a handwritten signature in black ink. The stamp contains the Mongolian text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТЫН АГНАА' (State Audit Agency of Mongolia) and 'Төрийн аудитын байгууллага' (State Audit Agency). The signature is written in a cursive style.

М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>117,780,565.82</u>	<u>129,088,747.82</u>
33	АВЛАГА	5,143,086.00	500,000.00
335	Бусад авлага	5,143,086.00	500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	5,143,086.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	112,637,479.82	128,588,747.82
354	Хангамжийн материал	104,737,479.82	116,691,414.82
35410	Бичиг хэргийн материал	632,100.00	788,100.00
35420	Аж ахуйн материал	104,105,379.82	115,903,314.82
35600	Мал амьтад	7,900,000.00	11,897,333.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,536,310,852.78</u>	<u>1,770,924,170.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,536,310,852.78	1,770,924,170.54
392	Биет хөрөнгө	1,315,133,652.78	1,532,058,970.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,127,500,301.17	1,193,359,301.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-109,036,648.99	-154,379,415.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,307,800.00	375,107,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-95,479,678.22	-117,032,644.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,783,236.40	177,514,427.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,828,138.74	-81,053,246.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,043,335.00	88,004,335.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-68,706,625.83	-71,850,509.93
39209	Зам, гүүрний байгууламж	98,154,567.00	98,154,567.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-8,442,428.07	-11,714,247.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,985,359.30	64,985,359.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-25,377,986.24	-30,267,315.86
39217	Ном	1,230,560.00	1,230,560.00
393	Биет бус хөрөнгө	221,177,200.00	238,865,200.00
39301	Программ хангамж	2,932,000.00	2,932,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,482,000.00	-2,632,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	220,727,200.00	238,565,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,654,091,418.60</u>	<u>1,900,012,918.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,366,685.00</u>	<u>14,985.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,366,685.00	14,985.00
413	Өглөг	1,366,685.00	14,985.00
4136	Бусад өглөг	1,366,685.00	14,985.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,366,685.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	14,985.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,652,724,733.60</u>	<u>1,900,012,918.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,652,724,733.60	1,899,997,933.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	993,103,372.67	1,010,941,372.67
51101	Өмч: - төрийн	993,103,372.67	1,010,941,372.67

512	Хуримтлагдсан үр дүн	371,915,586.47	601,350,786.23
51210	Өмнөх үеийн үр дүн	371,915,586.47	371,915,586.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	229,435,199.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,705,774.46	287,705,774.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,654,091,418.60	1900,012,918.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	576,205,389.00	872,735,590.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,155,403.00	287,123,559.40
120	Нийтлэг татварын бус орлого	83,155,403.00	287,123,559.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,155,403.00	1,772,935.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	848,419.00	1,439,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,306,984.00	333,935.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,049,986.00	585,612,031.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,376,086.00	7,395,331.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,700,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,676,086.00	7,195,331.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,673,900.00	578,216,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,673,900.00	578,216,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	503,284,256.19	643,212,890.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,284,256.19	566,212,890.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	457,053,376.69	535,489,934.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,748,589.50	267,022,360.57
210101	Үндсэн цалин	208,257,622.50	216,950,682.57
210102	Нэмэгдэл	00.00	32,348,683.00
210104	Урамшуулал	00.00	1,128,597.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,490,967.00	16,594,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,936,550.00	33,498,785.00
210201	Тэтгэврийн даатгал	21,364,259.00	23,293,218.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,018,307.00	2,273,772.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,985,323.00	1,725,314.01
210204	Ажилгүйдлийн даатгал	2,522,885.00	1,305,047.46
210205	Эрүүл мэндийн даатгал	5,045,776.00	4,901,432.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,214,064.00	36,631,589.00
210301	Гэрэл, цахилгаан	2,434,180.00	2,854,393.00
210302	Түлш, халаалт	34,779,884.00	33,777,196.00

2104	Хангамж, бараа материалын зардал	28,913,684.00	38,261,808.00
210401	Бичиг хэрэг	3,274,380.00	3,043,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,161,594.00	26,930,708.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,886,260.00	2,094,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	892,000.00	1,481,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,336,450.00	4,670,400.00
210408	Бараа материал акалсны зардал	3,363,000.00	41,000.00
2105	Нормативт зардал	666,400.00	666,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	666,400.00	666,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,742,000.00	4,156,400.00
210604	Урсгал засвар	7,742,000.00	4,156,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,902,000.00	5,839,885.00
210702	Дотоод албан томилолт	1,902,000.00	5,839,885.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,320,935.00	3,168,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,209,271.00	1,308,071.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,000.00	118,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,400.00	178,149.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	542,600.00	760,200.00
210807	Газрын төлбөр	1,920,464.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,609,154.19	146,244,186.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,697,212.00	45,632,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	296,000.00	5,226,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,615,942.19	95,385,373.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,230,879.50	30,722,956.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,907,400.00	16,047,228.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	15,216,228.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,474,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,433,000.00	831,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,323,479.50	14,675,728.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,323,479.50	13,022,982.43
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,652,746.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	72,921,132.81	229,522,699.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,500.00	87,500.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	29,500.00	87,500.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-29,500.00	-87,500.05
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	72,891,632.81	229,435,199.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	505,891,330.00	587,069,031.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,935,508.00	1,457,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,935,508.00	1,457,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,935,508.00	1,439,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,935,508.00	1,439,000.00
120009	Бусад орлого	00.00	18,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	496,955,822.00	585,612,031.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,281,922.00	7,395,331.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,700,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,581,922.00	7,195,331.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,673,900.00	578,216,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,673,900.00	578,216,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	505,891,330.00	477,119,131.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,891,330.00	477,119,131.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,639,764.50	445,896,174.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,518,636.50	266,794,245.57
210101	Үндсэн цалин	208,532,579.89	216,722,567.57
210102	Нэмэгдэл	00.00	32,348,683.00
210104	Урамшуулал	00.00	1,128,597.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,986,056.61	16,594,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,139,700.00	33,622,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,727,800.00	22,867,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,603,000.00	2,690,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,082,400.00	2,152,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	520,600.00	532,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,205,900.00	5,380,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,270,407.00	36,649,246.00
210301	Гэрэл, цахилгаан	2,490,523.00	2,872,050.00
210302	Түлш, халаалт	34,779,884.00	33,777,196.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,475,990.00	36,395,236.00
210401	Бичиг хэрэг	3,160,180.00	3,199,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,851,100.00	24,355,636.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,811,260.00	2,094,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	892,000.00	1,481,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,761,450.00	5,263,900.00

2105	Нормативт зардал	666,400.00	666,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	666,400.00	666,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,794,400.00	4,206,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	3,794,400.00	4,206,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,902,000.00	5,824,900.00
210702	Дотоод албан томилолт	1,902,000.00	5,824,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,417,935.00	11,168,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,306,271.00	9,308,071.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	109,000.00	118,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,400.00	178,149.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	542,600.00	760,200.00
210807	Газрын төлбөр	1,920,464.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,344,296.00	50,568,727.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,751,796.00	45,312,167.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	592,500.00	5,256,560.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,251,565.50	31,222,956.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,907,400.00	16,047,228.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	15,216,228.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,474,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,433,000.00	831,000.00
2133	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох татаас, санхүүжилт, шилжүүлэг	35,344,165.50	15,175,728.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,323,479.50	13,022,982.43
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,020,686.00	2,152,746.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	83,143,300.00	109,949,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	83,143,300.00	109,949,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	83,143,300.00	109,949,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	83,143,300.00	109,949,900.00
223001	Бусад хөрөнгө	00.00	77,000,000.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	83,143,300.00	32,949,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-83,143,300.00</u>	<u>-109,949,900.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	993,103,372.67	287,705,774.46	304,776,868.77	1,585,586,015.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	993,103,372.67	287,705,774.46	304,776,868.77	1,585,586,015.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	67,138,717.70	67,138,717.70
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	993,103,372.67	287,705,774.46	371,915,586.47	1,652,724,733.60
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	993,103,372.67	287,705,774.46	371,915,586.47	1,652,724,733.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	993,103,372.67	287,705,774.46	371,915,586.47	1,652,724,733.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	17,838,000.00	00.00	00.00	17,838,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	229,435,199.76	229,435,199.76
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,010,941,372.67	287,705,774.46	601,350,786.23	1,899,997,933.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	579,416,700.00	566,650,717.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,416,700.00	471,650,717.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,846,400.00	455,603,489.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,127,300.00	266,794,245.57
210101	Үндсэн цалин	249,967,300.00	216,722,567.57
210102	Нэмэгдэл	0.00	32,348,683.00
210104	Урамшуулал	0.00	1,128,597.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,160,000.00	16,594,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,628,500.00	33,622,500.00
210201	Тэтгэврийн даатгал	22,867,300.00	22,867,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,690,300.00	2,690,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,152,200.00	2,152,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,100.00	532,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,380,600.00	5,380,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,752,900.00	36,649,246.00
210301	Гэрэл, цахилгаан	4,253,200.00	2,872,050.00
210302	Түлш, халаалт	36,499,700.00	33,777,196.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,525,400.00	33,895,900.00
210401	Бичиг хэрэг	1,964,400.00	3,109,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,947,700.00	21,946,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,349,400.00	2,094,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,481,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,263,900.00	5,263,900.00
2105	Нормативт зардал	666,400.00	666,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	666,400.00	666,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,156,400.00	16,156,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,950,000.00	11,949,900.00
210604	Урсгал засвар	4,206,400.00	4,206,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,824,900.00	5,824,900.00
210702	Дотоод албан томилолт	5,824,900.00	5,824,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,038,000.00	10,318,621.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,880,000.00	8,458,172.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	410,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,000.00	118,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,400.00	178,149.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	762,600.00	760,200.00
210807	Газрын төлбөр	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,126,600.00	51,675,377.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,860,100.00	46,418,817.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,266,500.00	5,256,560.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,570,300.00	16,047,228.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,570,300.00	16,047,228.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	15,216,228.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	831,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,000,000.00	95,000,000.00
223001	Бусад хөрөнгө	95,000,000.00	95,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	579,416,700.00	566,650,717.57
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	579,216,700.00	565,193,717.57
320001	Орон нутгийн төсвөөс	579,216,700.00	565,193,717.57
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	1,457,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	1,457,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	53.00	53.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын Засаг даргын тамгын газар нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Ховд сумын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 245,621.4 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	5,143.1	500.0	-4,643.1
Урьдчилгаа			
Бараа материал	112,637.4	128,588.7	15,951.3
Үндсэн хөрөнгө	1,536,310.9	1,770,924.2	234,613.3
Нийт хөрөнгө	1,654,091.4	1,900,012.9	245,921.5
Өр төлбөр	1,366.7	15.0	-1,351.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,652,724.7	1,899,997.9	247,273.2

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,654,091.4	1,900,012.9	245,921.5
--	-------------	-------------	-----------

Бараа материалын дансны үлдэгдэл 128,588.7 мянган төгрөг болж 15,951.3 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, мал амьтад нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,770,924.2 мянган төгрөг болж 234,613.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн болон улсын төсвийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,899,997.9 мянган төгрөг болж 247,273.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 369,596.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 369,596.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 206,820.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 579,416.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 579,416.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 579,216.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 578,216.7 мянга, үйл ажиллагааны орлого 1,439.0 мянга, нийт 579,655.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 566,650.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 566,650.7 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь зардлыг 12,766.0 мянган төгрөгөөр хэмнэж, үндсэн үйл ажиллагааны орлого 239.0 мянган төгрөгөөр илүү бүрдэж, 18.0 төгрөгийн бусад орлого олсонтой холбоотой байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	247,207.1	246,839.3	367.8	99.9
2	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Баг хорооны үйл ажиллагааны зардал-80106	69,987.3	66,924.3	3,063.0	95.6
3	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	43,484.1	39,770.3	3,713.8	91.5

4	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Нийтлэг үйлчилгээ -80112	44,327.8	43,642.8	685.0	98.5
5	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Мэдээлэл сурталчилгааны зардал -80205	250.0	250.0	0.0	100.0
6	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг -80802	833.0	831.0	2.0	99.8
7	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж -213403	16,737.3	15,216.2	1,521.1	90.9
8	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Бусад -80918	95,000.0	95,000.0	0.0	100.0
9	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Орон нутгийн нөөц хөрөнгө -81102	16,500.0	14,426.1	2,073.9	87.4
10	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх- 81701	37,090.1	35,262.1	1,828.0	95.1
11	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Хур хог хаягдал орчны бохирдол-82212	2,000.0	1,481.6	518.4	74.1
12	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Мал тооллого -81507	1,200.0	1,200.0	0.0	100.0
13	ОН-гүйцэтгэх засаглалын удирдлага -70106: Улсын их баяр наадам -82801	4,000.0	4,000.0	0.0	100.0
14	Ахмад настны хөгжил хамгаалал – 72208 Ахмадын сан - 81549	600.0	600.0	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,195.3 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 200.0 мянга нийт 7395.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 5,242.9 мянган төгрөгийг зарцуулж 2,152.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 575.2 сая төгрөгийн 1.0 хувь буюу 5.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 4.6 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 134, хугацаа хоцроож байршуулсан 13, байршуулаагүй 2, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ховд сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Р.АЮУШ/

2023 оны 02 сарын 24-ний өдөр